



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 03 өдөр

Дугаар A/526

Арвайхээр

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн
байдлын зэрэгт шилжсэн үед авах зарим арга
хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "б", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Засгийн газрын 2020 оны "Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай" 194 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн, аймгийн хэмжээнд Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын баруун түр хяналтын цэг, Онгийн голын байнгын хяналтын цэг, Хархорин сумын Орхон голын гүүрийн түр хяналтын цэг, Туркийн замын байнгын хяналтын цэг, Тарнын гүүрийн байнгын хяналтын цэг, Нарийнтээл сумын байнгын хяналтын цэгүүдийг 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэл ажиллуулж, бусад хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 06:00 цагаас эхлэн зогсоосугай.

2. Халдвартай бүсээс ирсэн иргэдийг гэрийн хязгаарлалтад 14 хоног байх хугацаанд халдвартай хамгааллын дэглэмийг мөрдүүлж, хяналт тавьж, хамтран ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Эрүүл мэндийн газар (Д.Шиваанүрдэв), сум, багийн Засаг дарга нар, СӨХ-ийн дарга, гудамж, хэсгийн ахлагч, Улаан загалмайн хорооны сайн дурын идэвхтэн гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

3. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлж, хүнсний худалдааны газруудын ажиллах цагийн хуваарийг 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 09:00-19:00 цаг, бусад худалдаа, үйлдвэр, үйлчилгээний байгууллагуудыг 10:00-17:00 цаг хүртэл ажиллуулсугай.

4. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 06:00 цагаас 12 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчилгээний түр хориглосугай.

5. Аймгийн төв бараан зах болон худалдаа, үйлчилгээний төвүүдэд бараа, бүтээгдэхүүнийг ил задгай, гадна талбайд худалдан борлуулах, улсын чанартай авто замын дагуух үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний газрууд (зоогийн газар, ресторан, цайны газар)-ын үйл ажиллагааг 12 дугаар сарын 04-11-ний өдрийн 06:00 цаг хүртэл түр хориглосугай.

011101195

2.

6. Сүм хийдүүд үйл ажиллагаа явуулахдаа иргэд, олон нийтээс цахимаар болон үүрэн телефоны утсаар захиалга, үйлчилгээний хүсэлтийг авч олон нийтийг цуглуулахгүйгээр, халдварт хамгааллын дэглэмийг чанд мөрдөн, дотоод үйл ажиллагаагаа (ном хурах) зохицуулж ажиллахыг чиглэл болгосугай.

7. Олон нийтийг хамарсан урлаг, спортын нэгдсэн арга хэмжээ, цахим тоглоомын газар, интернет кафе, бүх төрлийн сургалтын үйл ажиллагаа, хурал, жагсаал цуглааныг дээрх хугацаанд зохион байгуулахыг түр хориглосугай.

8. Худалдаа, үйлчилгээний аж ахуйн нэгжүүдэд халдварт хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж, худалдаа үйлчилгээ эрхлэгч, лангуу түрээслэгчдийн ар гэрт голомтот бүсээс хүн ирсэн тохиолдолд гэрийн хязгаарлалтад 14 хоног байж үйл ажиллагаа явуулахгүй байх, үйлчлүүлж байгаа иргэдийн биеийн халууныг хэмжиж, амны хаалт зүүсэн эсэхэд хяналт тавин нэг удаагийн бээлий, гар ариутгагчаар хангаж үйлчилгээ үзүүлэх болон байгууллагын орчны хяналтын камерын байнгын ажиллагааг хэвшүүлж, камерын бичлэгийг 30 хоног хүртэл хадгалж архивлахыг үүрэг болгосугай.

9. Дээрх худалдаа, үйлчилгээний, төвүүдийн гадна, дотор талын ариутгал, халдвартгүйтгэлийг тогтмол хийлгэж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Зоонозын өвчин судлалын төв (Б.Сүхбаатар), сумын Засаг дарга наарт тус тус даалгасугай.

10. Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшигас хамгаалах бэлэн байдлын зэргийг бууруулсантай холбогдуулан төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг тасралтгүй явуулж, олон нийтийн эргүүл, явуулын түр цэгийн үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, хяналт тавин ажиллахыг сумдын Онцгой комисст даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ

